



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/65

Арвайхээр

Албан тушаалын тодорхойлолт батлах
тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 194 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Сум, багийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч нарын гэрээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хүний эрх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хууль тогтоомжийн лавлагаа, хяналт, мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээний салбарын бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Барилга, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын салбарын бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Эрүүл мэндийн бодлого зохицуулалт, жендерийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Хүн ам зүй, хөдөлмөр, халамжийн салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Соёл, урлаг, биеийн тамир, спорт, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан

012100231

2.

мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Төсвийн зарлагын ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Төсвийн орлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хөтөлбөр, сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх хавсралтаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны албан хаагчдад танилцуулан, хувийн хэрэгт хийж ажиллахыг Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ДАРГА

A red square stamp with Mongolian text is centered on the page. A black handwritten signature is written across the stamp. The signature appears to be 'Ц.ГАНБОЛД'.

Ц.ГАНБОЛД